

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 01

Улаанбаатар хот

Байгууллагын 2025 оны дотоод аудитын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/120 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”-д үндэслэн эрсдэлийн үнэлгээг хийлээ.

Эрсдэлийг бууруулах, удирдах зорилгоор төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдийн зохион байгуулсан үйл ажиллагаа, хэрэгжүүлсэн арга хэмжээнд тулгуурлан 8 эрсдэлийг тодорхойлж, дүн шинжилгээ хийн учирч болох эрсдэлийн ангилал тус бүрийг үнэлэхэд 89.15 хувиар дүгнэгдлээ.

Тайлант хугацаанд эрсдэлийг сааруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээний хүрээнд байгууллага дотооддоо арилган бууруулж, урьдчилан сэргийлэх зорилгоор дараах ажлыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Засгийн газрын 2024 оны 160 дугаар тогтоолын хүрээнд төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн төрийн тусгай 252, төрийн үйлчилгээний 64 албан тушаалын 316 орон тооноос буюу 79.7 хувь нь төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлд хамаарч, цалин хөлс, нэмэгдэл (онцгой нөхцөл, цол, төрийн алба хаасан хугацааны) дунджаар 64 орчим хувиар нэмэгдсэний үр дүнд 2021-2024 оны дунджийг 2025 оны эхний 11 дүгээр сарын байдлаарх шилжилт хөдөлгөөнтэй харьцуулахад ажлаас чөлөөлөгдсөн албан хаагч 62.5, төрийн бусад байгууллагад шилжих хөдөлгөөн 32.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

- “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системийн хэвийн ажиллагааг хангах хүрээнд байгууллагын даргын 2025 оны А/168 дугаар тушаалаар “Кибер аюулгүй байдлыг хангах журам”, А/475 дугаар тушаалаар “Кибер халдлага зөрчлийн үед хариу арга хэмжээ авах журам”, А/476 дугаар тушаалаар “Мэдээллийн системийн нөөцлөлт ба нөхөн сэргээх журам”-ыг баталж, мөрдөн ажиллаж байна.

- Цаасан суурьтай байнга хадгалах баримтыг эрсдэлээс хамгаалах хүрээнд и-архив программд 2024 онд 15219 файлыг холбосон, энэ оны байдлаар 16348 болж, 1129 файлаар буюу өнгөрсөн оноос 13 хувиар өссөн байна.

- Дотоод аудитын төлөвлөгөөний дагуу санхүү, үйл ажиллагааны чиглэлээр 6, нийцлийн чиглэлээр 3, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 3, нийт 12 удаагийн төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, үр дүнг илтгэх хуудсаар байгууллагын даргад танилцуулан, холбогдох арга хэмжээ авч ажиллалаа.

Байгууллагын хэмжээнд тохиолдож буй эрсдэлүүдийг дахин үнэлэхэд бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, төсөв хөрөнгөөс шалтгаалсан болон дээд шатны байгууллагаас хамааралтай эрсдэлүүд байна. Үүнд:

Нэг. Хэрэгцээ шаардлага буюу төсөв, санхүүгийн эрсдэл:

Дараа жилийн төсвийг батлахдаа байгууллагын өмнөх жилийн гүйцэтгэлээр баталдаг. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан төсвийн хүрэлцээгүй байдал үүссэнээр батлагдсан төсвийн ангиллыг хэтрүүлэх, зориулалтын бусаар зарцуулах эрсдэл

Хоёр. Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын чиглэлээр:

Нийтээр амрах баярын өдөр болон 7 хоног бүрийн амралтын өдөр, эсхүл ажлын бус цагаар гадаадын иргэний зөрчлийг илрүүлэн түр саатуулах тохиолдолд жижүүрийн шүүгч байдаггүйгээс зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа удаашрах эрсдэл

Гурав. Бусдаас хамааралтай буюу гадаад хүчин зүйлсийн эрсдэл:

“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) систем хэвийн ажиллагаа алдагдах, мэдээллийн сан устах, гэмтэх үед дахин сэргээгдэхгүй байхаас урьдчилан сэргийлэх эрсдэл

Дээрх эрсдэлийн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. Эрсдэлийн үнэлгээний матриц

ТОХИОЛДОХ МАГАДЛАЛ (тоон хэмжээс)	5	5	10	15	20	25
	4	4	8	A1, A2, B1	Г2	20
	3	3	Г1, Г3	9	12	15
	2	Б2	4	Б1	8	10
	1	1	2	3	4	5
	0	1	2	3	4	5
ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ (Тоон хэмжээс)						

Хүснэгт 2. Ач холбогдлын зэрэг тодорхойлох хүснэгт

Аудит хийгдэх эрсдэлүүд	Эрсдэлийн нийт тоон түвшин	Ач холбогдлын зэрэг	Аудит хийгдэх эсэх
Г2,	15-25	Их	Хамгийн их баталгаа өгөх аудит хийх
A1, A2, B1	12-20	Дунд	Байгууллагын түвшинд зохион байгуулах
Б1, Б2, Г1, Г3	1-10	Бага	Аудит хийх шаардлагагүй

Хүснэгт 3. Эрсдэл ангилсан хүснэгт

Д/д	Аудит хийгдэх эрсдэлүүд	Үйл ажиллагааны чиглэл	Тодорхойлсон эрсдэл
-----	-------------------------------	------------------------	---------------------

1	B1	Хэрэгцээ шаардлага буюу төсөв, санхүүгийн эрсдэл	Хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал хүрэлцэхгүй байх, санхүүгийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх
2	A1	Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл	Хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэдийг харьяатаас гаргахыг шаардах, аль нэг улсынхаа иргэний харьяаллаа сонгохыг тулгах эрх зүйн зохицуулалт байхгүйгээс хоёрдмол харьяалалтай иргэд нэмэгдэх
3	A2	Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл	Нийтээр амрах баярын өдөр болон 7 хоног бүрийн амралтын өдөр, эсхүл ажлын бус цагаар гадаадын иргэний зөрчлийг илрүүлэн түр саатуулах тохиолдолд жижүүрийн шүүгч байдаггүйгээс Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа удаашрах
4	B1	Үйл ажиллагааны буюу гүйцэтгэл, зохион байгуулалтын эрсдэл	Алслагдсан хилийн боомтод ажиллаж, амьдрах орчин нөхцөл бүрэн хангагдаагүйгээс ажиллах тогтворгүй байдал үүсэх
5	B2	Үйл ажиллагааны буюу гүйцэтгэл, зохион байгуулалтын эрсдэл	Хадгаламжийн нэгжүүд цаасан баримтад байгаа тохиолдолд эрсдэл бий болсноор нөхөн сэргээгдэх боломжгүй тул цахим хэлбэрт шилжүүлэх, хортон шавж, мэрэгч амьтдаас урьдчилан сэргийлэх
6	G1	Бусдаас хамааралтай буюу гадаад хүчин зүйлсийн эрсдэл	Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх
7	G2	Бусдаас хамааралтай буюу гадаад хүчин зүйлсийн эрсдэл	"Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан" (ISF) систем хэвийн ажиллагаа алдагдах, мэдээллийн сан устгах, гэмтэх үед дахин сэргээгдэхгүй байхаас урьдчилан сэргийлэх
8	G3	Бусдаас хамааралтай буюу гадаад хүчин зүйлсийн эрсдэл	Цахилгаан эрчим хүч, ус дулааны доголдол, гаднын нөлөөллөөс шалтгаалан бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан эвдрэх, сүлжээний техник хэрэгсэлд саатал учирч тасалдсанаар механик ажиллагаа явагдаж, үйл ажиллагааны ачаалал нэмэгдэж, мэдээллийн үнэн зөв, аюулгүй байдал алдагдах

**ДӨРӨВ. ЭРСДЭЛИЙГ СААРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БУЮУ
ХАРИУ АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ**

Д/д	Байгууллага дотооддоо удирдаад арилгаж, бууруулж, урьдчилан сэргийлж болох эрсдэл	Эрсдэлийг сааруулах хариу арга хэмжээ
1	2	3
1	Хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал хүрэлцэхгүй байх, санхүүгийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2026 оны төсвийн төслийн саналыг урт хугацааны бодлогын баримт бичиг, төв болон орон нутаг дахь нэгжүүдийн саналыг үндэслэн авлага, өглөг үүсгэхгүй үр дүнтэй байхаар тооцон 28,640.8 сая төгрөгөөр төлөвлөн боловсруулж, тайлбар танилцуулгын хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 01/1271 дугаар албан бичгээр хүргүүлж, Монгол Улсын 2026 оны төсөвт батлуулсан. Өр авлагыг хянаж, батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг энэ оны 01/490, 01/813, 01/1015, 01/1499, 01/1698, 01/1861, 01/2091 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, холбогдох зардлуудыг

		шийдвэрлүүлсэн бөгөөд улс орны эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж зарим зардлуудын төсвийн хуваарийн саналыг Сангийн яамнаас одоог хүртэл хойшлуулсаар байна. Дотоод аудитын төлөвлөгөөний дагуу санхүү, үйл ажиллагааны чиглэлээр 6, нийцлийн чиглэлээр 3, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 3, нийт 12 удаагийн төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийж, үр дүнг илтгэх хуудсаар байгууллагын даргад танилцуулан, холбогдох арга хэмжээ авч ажиллалаа.
2	Хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэдийг харьяатаас гаргахыг шаардах, аль нэг улсынхаа иргэний харьяаллаа сонгохыг тулгах эрх зүйн зохицуулалт байхгүйгээс хоёрдмол харьяалалтай иргэд нэмэгдэх	Байгууллагын даргын 2009 оны “Хоёрдмол харьяалалтай иргэдийн бүртгэл, судалгаа хөтлөх тухай” 275 дугаар тушаалын дагуу хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэдийг илрүүлсэн даруй тогтмол бүртгэн ажиллаж байна. Гадаадын иргэдийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд 54 улсын 5234 иргэн бүртгэлтэй байгаагаас тайлант хугацаанд 228 иргэнийг бүртгэжээ. Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн даргын энэ оны 17/34 дугаартай удирдамжаар 11 дүгээр сарын 18-ны өдөр аймгийнхаа хэмжээнд хувийн хэргээр оршин суух зөвшөөрөлтэй болон түр ирэгч Монгол Улсын харьяатаас гаралгүй Бүгд Найрамдах Казахстан Улсын харьяат болж, хоёрдмол харьяалал үүсгэсэн 63 иргэнд хяналт шалгалтыг зохион байгуулан ажилласан. Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их хурлын 07 дугаар сарын 09-ний өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталж, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 08 дугаар сарын 12-ны өдрийн №32(1377) дугаарт нийтлэгдсэн байна.
3	Нийтээр амрах баярын өдөр болон 7 хоног бүрийн амралтын өдөр, эсхүл ажлын бус цагаар гадаадын иргэний зөрчлийг илрүүлэн түр саатуулах тохиолдолд жижүүрийн шүүгч байдаггүйгээс Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа удаашрах	Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт хэрэглэх журам”, “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт шинэчлэн батлах” тухай Засгийн газрын тогтоолын төсөлд 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01/675 дугаар албан бичгээр хариуг ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Монгол Улсын Их хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр шинэчлэн баталсан Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3-т зааснаар Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх байгуулахаар тусгасан, уг шүүх эрүүгийн болон зөрчлийн хэрэг, таслан сэргийлэх арга хэмжээг харьяалан хянан шийдвэрлэхээр 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.2 дугаар зүйлд зааснаар гадаадын иргэнийг саатуулах буюу таслан сэргийлэх арга хэмжээг энэхүү шүүх харьяалан шийдвэрлэж, шүүн таслах үйл ажиллагаа ажлын өдөр бүрийн 22.00 цаг хүртэл тасралтгүй хэрэгжихээр зохион байгуулжээ.
4	Алслагдсан хилийн боомтод ажиллаж, амьдрах орчин нөхцөл бүрэн хангагдаагүйгээс ажиллах тогтворгүй байдал үүсэх	Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын дагуу хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн төрийн тусгай болон төрийн үйлчилгээний нийт 151 албан хаагчийн албан тушаалын үндсэн цалинг байгууллагын даргын 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/12 дугаар тушаалаар нэмэгдүүлэн шинэчлэн тогтоолоо. Байгууллагын хэмжээнд 75 удаагийн дотоод сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 2890 гаруй албан хаагч хамрагдсанаас Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад 16, Өмнөд Солонгос, Хятад, Энэтхэг, Унгар, Тайвань, Швейцар зэрэг улсад 63 албан хаагчийг сургалт,

		арга хэмжээнд хамруулав. Өмнөх оноос мэргэшүүлэх сургалт 62.5 хувиар, гадаад сургалт, арга хэмжээний хамрагдалт 26.9 хувиар тус тус өссөн. Албан хаагчдын ажиллах, амьдрах нөхцөлийг сайжруулах хүрээнд Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 04/05 дугаар тогтоолын хүрээнд тус газрын 2 албан хаагчийн орон байрны нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлж, Зүүн бүс дэх газар албан хаагчдын амьдрах 3 өрөө орон сууцыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлжээ. Дорноговь аймаг дахь газар албан хаагчдын бялдаржуулах өрөөг 05 дугаар сард засварлан тоног төхөөрөмж суурилуулан тохижуулж, Говьсүмбэр аймаг, Ханх, Ханги боомтын албаны болон амьдрах байрны зарим тавилгыг шинэчлэн урсгал засвар хийсэн. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Засгийн газрын 2024 оны 160 дугаар тогтоолын хүрээнд төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн төрийн тусгай 252, төрийн үйлчилгээний 64 албан тушаалын 316 орон тооноос буюу 79.7 хувь нь төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлд хамаарч, цалин хөлс, нэмэгдэл (онцгой нөхцөл, цол, төрийн алба хаасан хугацааны) дунджаар 64 орчим хувиар нэмэгдсэний үр дүнд 2021-2024 оны дунджийг 2025 оны эхний 11 дүгээр сарын байдлаарх шилжилт хөдөлгөөнтэй харьцуулахад ажлаас чөлөөлөгдсөн албан хаагч 62.5, төрийн бусад байгууллагад шилжих хөдөлгөөн 32.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
5	Хадгаламжийн нэгжүүд цаасан баримтад байгаа тохиолдолд эрсдэл бий болсноор нөхөн сэргээгдэх боломжгүй тул цахим хэлбэрт шилжүүлэх, хортон шавж, мэрэгч амьтдаас урьдчилан сэргийлэх	Байгууллагын даргын 2023 оны А/65 дугаар тушаалаар баталсан “Цахим баримт бүрдүүлэх, хөтлөх, архивд шилжүүлэх журам”-ын дагуу энэ оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар 2024 оны байгууллагын даргын тушаал, гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлдэг гадаадын төрийн бус байгууллага, 2023 оны гадаадын хөрөнгө оруулагчийн материал зэрэг нийт 129 хадгаламжийн нэгжийг сканердан цахим хэлбэрт шилжүүлж, и-архив программд шинээр 1131 файл үүсгэж, цаасан суурьтай баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, баримтын эх хувийг ашиглалтаас чөлөөлөх арга хэмжээ авсан. 2024 оны жилийн эцсийн байдлаар 15219 файлыг и-архив программд холбосон, энэ оны байдлаар 16348 болж, 1129 файлаар буюу өнгөрсөн оноос 13 хувиар өссөн байна. Төвийн байранд байрлах А, Б хадгаламжийн санд “Болор ариусгал” ХХК-иар 05 дугаар сарын 26, 10 дугаар сарын 01-ний өдөр хортон шавж устгалын ажил хийлгэж, архивын баримтыг эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авч ажиллалаа.
6	Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх	Тус байгууллага нь Гамшгийн үед ажиллах төлөвлөгөөг 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр баталсан, жил бүр төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ онд төвд 80 албан хаагчийн бэлэн байдлыг шалган нэг цэгт цуглуулж бэлэн байдлыг шалган, мэдээллийг албан бичгээр Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны Засаг даргад хүргүүлсэн. Мөн хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүд аймгийнхаа Онцгой байдлын газартай хамтран баталсан гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд 2025 онд тодотгол хийн, бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүд дараах хамтарсан сургалт, сургуулилтад оролцлоо. Үүнд: - Байгууллагын даргын 01-02/27 дугаар удирдамжийн дагуу Гамшгаас хамгаалах сургалтын төвөөс 05 дугаар сард зохион байгуулсан “Гамшиг эрсдэлийн үед авах арга

		хэмжээ”; - Хойд бүс дэх газар 02 дугаар сард Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газар, Улаан Загалмайн хорооны салбар нэгжтэй хамтран “Ой хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах”, “Зүрх, уушгины сэхээн амьдруулалд”; - Баян-Өлгий аймаг дахь хэлтэс 03 дугаар сард аймгийнхаа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ойлголт”, 09 дүгээр сард зохион байгуулагдсан “Сөргө 2025-II” стратегийн команд штабын сургуулилтад; - Зүүн бүс дэх газар 04, 05 дугаар сард “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ойлголт”, “Эрсдэлийн үнэлгээ хийх, зааварчилга хэрхэн өгөх тухай”; - Дорноговь аймаг дахь газар 09 дүгээр сард Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэгтэй хамтран “Зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх”, “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх”; - Агаарын замын боомт хариуцсан газар 09 дүгээр сард “Нью-Улаанбаатар Интернэшнл Эйрпорт” ХХК-аас зохион байгуулсан Нисэх буудлын онцгой нөхцөлийн төлөвлөгөөний Код-1 “Агаарын хөлгийн осол, зөрчил” сургуулилтад; - Өмнөд бүс дэх газар 10 дугаар сард Өмнөговь аймгийн Онцгой байдлын газартай хамтран “Галын аюулаас урьдчилан сэргийлэх”; - Баруун бүс дэх газар 11 дүгээр сард Ховд аймгийн Онцгой байдлын газартай хамтран “Галын аюулгүй байдал, түүнээс урьдчилан сэргийлэх нь” сургалтад хамрагдсан. Зүүн бүс дэх газар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар 02 дугаар сарын 18-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг мэргэшсэн багштай байгуулж, бүсийн төвд эрсдэлтэй ажлын байранд ажилладаг албан хаагчидтай уулзалт зохион байгуулж, хилийн Бичигт, Эрээнцав боомтод эрсдэлийн үнэлгээ хийлгүүлж ажилласан. Хойд бүс дэх газар 05 дугаар сард Сэлэнгэ аймгийн зарим сумдад гарсан түймрийн голомтод ажиллаж буй Онцгой байдлын албан хаагчид, аймгийнхаа Онцгой байдлын комиссын гишүүдэд “EcoFliv” генераторын цэнэглэгч төхөөрөмжийг хүлээлгэн өгч, гамшгийн эсрэг бэлэн байдалд ажилласан.
7	“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) систем хэвийн ажиллагаа алдагдах, мэдээллийн сан устгах, гэмтэх үед дахин сэргээгдэхгүй байхаас урьдчилан сэргийлэх	“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системийн хэвийн ажиллагааг хангах хүрээнд байгууллагын даргын 2025 оны А/168 дугаар тушаалаар “Кибер аюулгүй байдлыг хангах журам”, А/475 дугаар тушаалаар “Кибер халдлага зөрчлийн үед хариу арга хэмжээ авах журам”, А/476 дугаар тушаалаар “Мэдээллийн системийн нөөцлөлт ба нөхөн сэргээх журам”-ыг баталж, мөрдөн ажиллаж байна. Хэрэглэгчийн системд хандах эрх (google authenticator), төхөөрөмжийг бүртгэлжүүлэх эрхийн тохиргоог 138 хэрэглэгчдэд 06 дугаар сарын 11-нээс 09 дүгээр сарын 11-ний өдрийн хооронд хийж тохируулаад байна. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх МОН-3936 төслийн хүрээнд 5 ширхэг сервер компьютер 10 дугаар сарын 28-ны өдөр нийлүүлэгдсэн бөгөөд тус серверүүдийг Үндэсний дата төв УТҮГ-т 11 дүгээр сарын 27-ны өдөр хүлээлгэн өгч байршуулан давхар ажиллагааны сервер бэлтгэж байна.
8	Цахилгаан эрчим хүч, ус дулааны доголдол, гаднын нөлөөллөөс шалтгаалан бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан эвдрэх, сүлжээний	Байгууллага сүлжээний тасалдал үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор суурин 20, явуулын хяналт шалгалт хийх 8 цэгт ашиглагдах сансрын холбооны старлинк төхөөрөмжийг үйл ажиллагаанд нэвтрүүлэн “Мобинет”

техник хэрэгсэлд саатал учирч тасалдсанаар механик ажиллагаа явагдаж, үйл ажиллагааны ачаалал нэмэгдэж, мэдээллийн үнэн зөв, аюулгүй байдал алдагдах	ХХК-тай ГИХГ/20250103005 дугаартай гэрээ байгуулан хамтран ажилласан. Мөн ГИХГ/20240102010 дугаар тендер шалгаруулалтаар аваарын үед ашиглагдах 26 ширхэг серверийг 05 дугаар сарын 08-ны өдөр хүлээн авч, ашиглахад бэлэн болгосон. Цахилгааны тасалдлын үед ашиглагдах 75 кВт-ийн 2 ширхэг цахилгаан мотор хүний оролцоогүй автоматаар сэлгэлт хийн бэлэн байдалд ажиллаж байна. Байгууллагын дотоод хэрэгцээнд нарны цахилгаан үүсгүүрийг ашиглаж, эрчим хүчний зардлыг бууруулахаар төлөвлөн байгууллагын эзэмшлийн хоёр барилгын дээвэр дээр нарны цахилгаан үүсгүүр суурилуулахаар энэ оны 01/06-13 дугаар бүхий нарны цахилгаан үүсгүүрийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах гэрээг байгуулж, гүйцэтгэгч байгууллагаас гэрээнд заасан хугацаанд техник эдийн засгийн үндэслэлийг хүлээлгэн өгч, гэрээ дүгнэсэн актаар баталгаажуулан нийт 108 ширхэг нарны панел суурилууллаа. Баруун бүс дэх газар мэдээллийн сүлжээ тасалдах, шилэн кабелийн шөрмөсний гэмтэл гарсан үед ашиглах зорилгоор нэмэлт шөрмөсийг цэнэглэж бэлэн байдалд бэлтгэн, барилгад суурилуулсан дохиоллын системд нэмэлт цахилгааны эх үүсвэрийн баттерэйг байрлуулсан. Өмнөд бүс дэх газар серверийн өрөөнд цахилгааны тэжээлийн тасалдал үүсэх, хэлбэлзэхээс урьдчилан сэргийлж, сүлжээний тог баригч, хүний давхцахгүй өгөгдөл бүхий ухаалаг цоож, ус мэдрэгч төхөөрөмжийг суурилуулсан. Хойд бүс дэх газар Алтанбулаг боомт, Зүүн бүс дэх газар Хавирга, Ульхан боомтын ажлын байранд цахилгааны аюулгүйн нөөц мотор байршуулсан.
---	---